

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Доктор Ц.Цэрэндорж:

Саяын илтгэгчийн сэдэв бол урьд өмнө судлагдаагүй сэдэв байна. Хятадад сурсан оюутнуудын талаар дашрамын байдлаар хийгдсэн судалгаанууд байдаг. Миний хувьд Хятад судлалын салбарын хүн биш боловч «Дорно дахины судлалын хүрээлэн ТББ»-ын үүсгэн байгуулагчдын нэг тул хуралд дэмжлэг үзүүлж хамтран зохион байгуулж оролцож байна. Энэ хуралтай, илтгэлтэй холбоотой ерөнхий санал хэлэхэд зөвхөн Монгол талаас харж асуудалд хандах нь түгээмэл, материал хэрэглэгдэхүүний байдал, янз бүрийн шалтгааны улмаас ерөнхийдөө хоёр улсын харилцаа ярихаар Монгол талаас харсан өнцөг давамгайлаад явчихдаг нь үндсэндээ бидний бодит байдал болчихоод байгаа юм. Монгол-Хятадын харилцааг Хятадын талаас харах, Монгол-Оросын харилцааг Оросын талаас харах байр суурь бас хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, аливаа юмыг нэг талаас нь харахаар ганцхан тэр өнцөг харагдана, аль болох тойроод бүх өнцгөөс нь харахыг оролдох нь цаашдаа бидний аргазүйн хувьд заавал харгалзан үзэх ёстой асуудал гэж бодож байна. Юмыг нэг талаас харахаар тухайн асуудал үнэхээр чухал юм шиг санагдаж болох ч ерөнхий утгаар нь авч үзэхэд харьцангуй байдаг. Өөрийн олдсон материал дээр тулгуурлаж, Монголын өнцгөөс харж байгаа ч тухайн үеийн Хятадын хувьд Монгол ямар байв, тэд ямар бодлого явуулж байв гэдгийг судлахгүй бол нэг талыг харсан дүгнэлт гарах талтай. Нөгөөтээгүүр, бид түүхээс сургамж авах ёстой. Бид голдуу ойд зориулсан хурал дээр магтан дуулах, сайн талыг нь ярьдаг талтай. Тэгэхээр сөрөг талыг нь ч бас ярих, аль алийг нь түүхэн сургамжийн үүднээс тодруулах шаардлага байна. Амжилт ололтоос гадна алдаа дутагдлыг зохих хэмжээнд ярьж байвал түүхэн сургамж талаасаа ач холбогдолтой гэж үзэж байна.

Яг энэ илтгэлийн тухайд хэлэхэд нэлээд материал цуглуулж, түүндээ тулгуурлаж хийгдсэн нь харагдлаа. Гэхдээ сая миний хэлсэнтэй холбогдуулан цаашдаа Хятад талын баримтуудыг үзэх, Хятадын өнцөг хараасыг анхаарах хэрэгтэй санагдлаа. Монгол суралцагчид тэдний хувьд хэн байв, тэднийг маань хятадууд ямар зэрэгт авч үзэж, үнэлж байв. Тухайн үед Хятадад суралцаж байсан нийт гадаадынхны дунд монгол оюутнууд ямархан байр байдалтай байв, аль зэрэг жин дарж байв гэх зэргийг харах хэрэгтэй. Тэгвэл бүрэн бүтэн олон талыг харгалзсан нэлээд сайн судалгаа болох боломжтой санагдав. Баярлалаа.

Доктор Б.Энхчимэг:

Бид өмнө нь голчлон Монголоос Хятадад очиж суралцсан оюутнуудыг бичдэг, ярилцдаг байж. Харин энэ илтгэлд Хятадаас Монголд суралцаж байсан оюутнуудын талаар оруулсан нь сонирхолтой, шинэлэг байлаа.

Хэлэлцээрийн дараа Хятадад сурахаар явсан анхны гурван оюутан бол Ч.Далай, Д.Бандихүү, Р.Гүрбазар нар юм. Тэдний хоёр нь түүхийн чиглэлээр, нэг нь хэлний чиглэлээр суралцсан билээ. Тухайн үед төрийн бодлогоор эдгээр оюутнуудыг явуулсан байдаг. Дараа нь бакалаврын түвшинд Л.Маналжав, Чой.Лувсанжав, Б.Гомбосүрэн, Г.Амийль, докторантурт Л.Жамсран, Г.Сүхбаатар, Н.Ишжамц, И.Чимэдцэрэн, Ч.Жүгдэр гэх мэт хожим манай Монголын нэртэй эрдэмтэд болсон хүмүүс суралцсан юм.

Илтгэлд өгүүлсэнчлэн Хятадад докторын зэрэг олгодоггүй байсан ч манай улс төгсөөд ирсэн хүмүүсийн эрдмийн зэргийг зөвшөөрсөн юм. Хятадад түүхийн чиглэлээр анх докторын зэрэг хамгаалсан хүн бол Л.Жамсран гуай байв. Түүх, хэл шинжлэлийн салбарын тухайд авч үзвэл илтгэлд нэр дурдагдсан хүмүүс бол Монголын түүхийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан, манай улсад орчин үеийн Хятад судлалыг хөгжүүлэх суурь тавилцсан хүмүүс байдаг. Мөн өөрсдөө суралцсанаас гадна, 1957 оноос эхлэн МУИС-д Хятад хэлний ангийг нээж, дотоодод боловсон хүчнээ бэлтгэж эхэлсэн. Хятадад төгссөн Л.Маналжав, Ч.Далай зэрэг эрдэмтэд тэнд багшилж байжээ. Харамсалтай нь 1962 оноос Монгол-Хятадын харилцаа хүйтэрч эхэлсэн нь Зөвлөлт-Хятадын харилцаа муудаж эхэлсэнтэй холбоотой байв. 1966 оноос Соёлын хувьсгал эхэлсэнтэй холбогдуулан 10-аад жил Монгол-Хятадын харилцаа зогсонги байдалд орсноос болж, МУИС-д нээгээд байсан хятад хэлний анги түр хугацаанд хаагдаж байв. Гэвч Хятадад суралцаж, төгсөж ирсэн эрдэмтэд өөрсдийнхөө судалгааг хийж, зарим нь үзэл суртлын шинжтэй судалгаа хийж, улсын байгууллагад ажиллаж байсан.

Миний бие 2015 онд Тайваньд Монголын Хятад судлалын талаар өгүүлэл хэвлүүлсэн. Тэнд Монголын Хятад судлалыг гурван хэсэгт хуваан авч үзсэн юм. Нэгт, шинэ Хятад улсад суралцаж ирсэн, Хятад судлалын суурийг тавьсан оюутнуудын талаар. Хоёрт, Хүйтэн дайны үед буюу 1960-1980 он гартал Зөвлөлтөд хятад судлаачдыг бэлтгэсэн талаар. Үүнд Ж.Баясах, Ч.Батцэцэг, Н.Ариунгуа гэх мэтчилэн хүмүүс суралцсан тухайг дурдсан. Мөн МУИС-д Хятад хэлний ангийг сэргээн хичээллүүлснээр Д.Баярхүү, Д.Шүрхүү, Д.Болдбаатар, М.Чимэдцэеэ гэх хүмүүс тэнд суралцаж төгссөн, багшаар нь Бээжинд суралцсан Чой.Лувсанжав ажиллаж байсан тухайд дурдсан. Гуравт, дараагийн үеийг 1990-ээд оноос эхлүүлэн авч үзсэн юм. Хоёр улсын харилцаа сайжирсантай холбоотойгоор их сургуулиуд болон дунд сургуулиудад хятад хэлний анги олноор нээгдэж түүнд нь маш олон хүн хятад хэл сурах болжээ. 2010 оноос хойш энэ байдал нэлээн өргөжсөн. Монголчууд бид өөрсдөө Хятад судлалын олон зуунаар тоологдох уламжлалтай ард түмэн. Энэ уламжлалаа алдалгүйгээр өдий хүргээд, улам өргөжүүлж, хөгжүүлж байгаад баяртай байна.